



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ 06 ДУГААР САРД
ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

СӨҮЛ ХОТ

2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд Монгол Улс, БНСУ-ын Хөдөлмөрийн Яам хоорондын “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоо”-ны дагуу БНСУ-д ажиллах хүч илгээх тухай харилцан ойлголцлын санамж бичиг, ХНХЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд ажил олгогч, ажилтан хоёрын хооронд байгуулсан хөдөлмөрийн гэрээнд хяналт тавьж биелэлтийг хангуулах, бусад холбогдох хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэн, БНСУ-д ажиллаж амьдарч буй иргэдийнхээ эрх ашгийг хамгаалан ажиллаж байна.

1. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААТАЙ ХОЛБООТОЙ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2024 оны 06 дугаар сарын 01-ээс 30-ны өдрийн хооронд хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр БНСУ-д ажиллаж, амьдарч буй иргэдэд газар дээр нь очиж үйлчлэхээс гадна танхимаар болон цахимаар, утсаар хандсан нийт 343 иргэнд үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, Үндэсний тэтгэврийн алба болон ажил олгогч эзэд, холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, сэтгэл засал, хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх зэргээр үйлчилгээ үзүүлэн, иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх чиглэлээр хамтран ажиллав.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын Самсунг даатгалын 13 дахь сарын цалин, нутаг буцах замын зардал, олгогдоогүй цалин хөлс, үйлдвэрээс авах цалингийн зөрүү зэрэг нийтдээ 48,806,608 воныг Монгол Улсын иргэдэд олгууллаа.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасгийн сар тутмын тоон мэдээ

/2024 оны 06 дугаар сар/

№	Агуулга	Дүн
1	Иргэдэд олгуулсан мөнгөн дүн	48,806,608
2	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол	343

2. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, НИЙГМИЙН ДААТГАЛТАЙ ХОЛБООТОЙ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД

2.1. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох ажлын хүрээнд

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд 28 иргэнийг шинээр хамруулан “Солонгос Улсад гэрээгээр ажиллагсдын программ”-д мэдээллийг бүртгэн гэрээ байгуулав. Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд даатгуулсан иргэдэд шинээр 24, гэрээний хугацаа сунгасан 33, ажлын байраа сольсон, гэрчилгээг гээж үрэгдүүлсэн, албан байгууллага нь хүсэлт гаргасан 8 даатгуулагчид Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг тус тус бичиж олгов.

2.2. БНСУ-д оршин сууж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох

Нийт 31 иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулав. БНСУ-ын ААН-д хөдөлмөр эрхэлдэг 24 даатгуулагчийн хүсэлтийн дагуу Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг бичиж олгов.

2.3 Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд

НДЕГ-ын даргын 2024 оны А/02 дугаар тушаалаар тус тасгийн 2024 оны орлогын төлөвлөгөө 4,997,799,000.00 төгрөгөөр батлагдсан бөгөөд сар бүрийн орлогын төлөвлөгөө 416,483,250.00 төгрөг болно.

Тус тасаг нь тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэл 47,730,000.00 вон буюу 116,938,500.00 төгрөг, сайн дурын даатгалын шимтгэл 122,244,251 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 57 хувиар биелүүлсэн.

Орлогын төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт-1
/2024.06.30-ны байдлаар/

Сар	Сарын орлогын төлөвлөгөө /төгрөгөөр/	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого		Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого	Нийт төвлөрүүлсэн шимтгэлийн орлого		Биелэлтийн хувь	Тухайн сарын МБ-ны эхний даваа гарагийн хаалтын ханш
		Воноор	Төгрөгөөр	Төгрөгөөр	Воноор	Төгрөгөөр		
6	416,483,250.00	47,730,000.00	116,938,500.00	122,244,251.00	47,730,000.00	239,182,751.00	57	2.45

Солонгос Улсад гэрээгээр ажиллагсдын программ, сайн дурын даатгалын нэгдсэн программд даатгуулагчдын гэрээний хугацаа, шимтгэл төлөлтийн тооцоог тус тус хянаж ажиллав.

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын ажил олгогчдод тухайн сарын болон өмнөх саруудын шимтгэл төлөхийг сануулж, 429 ширхэг нэхэмжлэл факсаар илгээн, нийт 480 даатгуулагчтай шимтгэл төлөхийг шаардаж утсаар холбогдов.

2.4. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр (Е-9, Н-2 оршин суух эрхээр) ажиллах хугацаандаа тус улсын Үндэсний тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн иргэдийн шимтгэлийг буцаан олгуулах ажлын хүрээнд

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулаад нутаг буцсан, төлсөн шимтгэлээ буцааж авахаар хүсэлт ирүүлсэн 206 дугаар ээлжийн 1 иргэний материал НДЕГ-аас ирснийг БНСУ-ын УТА-д хүргүүлэв. Өмнө нь УТА-д илгээсэн 194-202 дугаар ээлжийн 47 иргэний 270,953,900 вон шийдвэрлэгдэж, иргэдийн дансанд шилжсэн байна.

3. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН БУСАД АЖЛУУД

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар БНСУ-д 6 сарын 13, 14-ний өдрүүдэд Өижонбү, Пажү, Сөүл хотод ажиллаж амьдарч буй иргэдтэй уулзалт хийж, хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийн үйлдвэр дээр очиж ажиллан нийтдээ 74 иргэнтэй уулзалт хийсэн.

Төрийн үйлчилгээний “Хурдан” системийн цахим гарын үсгийн төхөөрөмжийг шинэчлэн суулгуулж, үйлчилгээ үзүүлэх сургалтад хамрагдан, БНСУ-д ажиллаж амьдарч буй иргэдэд төрийн үйлчилгээг хурдан шуурхай үзүүлж байна.

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийн сэтгэл зүйн тулгамдсан асуудлаар утсаар, танхимаар болон зарим тохиолдолд биечлэн очиж сэтгэл зүйн зөвлөгөө өгч, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэн ажилласан. Үүнд, ганцаарчилсан сэтгэл засал 12 хүнд, утсаар 10 хүнд зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. Сэтгэл гутрал болон түгшилтийг илрүүлэх сорил тус бүр 6 удаа, архины хамаарал илрүүлэх сорил 1 хүнд хийсэн.

Монголчууд олноор явдаг сүмд амралтын өдрөөр очин, Төвийн үйл ажиллагааны талаар болон хөдөлмөрийн харилцаа, Нийгмийн даатгалын багц хуулийн талаар танилцуулга хийж, иргэдийн асуултад хариулж, зөвлөгөө мэдээлэл өгсөн. Үүнд: 2024.06.02-нд Инчон хотын Пучён дүүргийн Монгол цуглаанд ирсэн 19 иргэн, 2024.06.16-нд Бупён дүүргийн Монгол цуглаанд ирсэн 9 иргэн, 2024.06.30-нд Сөүл хотын Жунну дүүрэгт байрлах Монгол цуглаанд ирсэн 19 иргэн, нийт 40 иргэнд хүрч ажилласан.

3.1 Мэдээлэл, сурталчилгааны ажлын хүрээнд

Төвийн БНСУ дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” социал хуудсанд 15 удаа, байгууллагын “<https://seoulcenter.mlsp.gov.mn>” цахим хуудсанд мөн 12 удаагийн мэдээлэл, зөвлөгөө нийтэлж, БНСУ-д амьдарч буй иргэдийн өргөн ашигладаг социал хуудсууд /“Нүүдэлчин Монголчууд”, “Дэлхийн Монголчуудын радио-MGLRADIO”, “Гэрээнийхэн наашаа E-9”, “Солонгос дахь Монголчуудын нэгдсэн групп”, “ХХҮЕГ БНСУ-д хөдөлмөрийн гэрээний ажилтан”/-д түгээн сурталчилсан.

E-9 визээс ахисан түвшний мэргэжлийн ур чадвартай ажиллах хүчний E-7-4 визний статус руу өөрчлөх, тогтвор суурьшилтай ажиллаж буй иргэдийн тоог нэмэгдүүлэх, монгол хүний хөгжлийг ахисан түвшинд хүрэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2 удаагийн танилцуулах бичлэг хийж, Төвийн цахим хуудсанд байршуулсан нь 1680 гаруй хүнд хүрсэн байна. Мөн 8 иргэний K-пойнт оноог тоолон, Топик болон Нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн шалгалтад бэлтгэх суваг, шалгалтын хуваарь зэрэг хэрэгцээт мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилласан.

2024 оны 06 сарын 24-ний өдөр Гёнги аймгийн Хвасон хотын баттерейны үйлдвэрт гал гарч, олон гадаад ажилчид нас барсантай холбогдуулан тухайн өдөр ойролцоох хотын гэрээт иргэдтэй холбогдон сэрэмжлүүлэг мэдээ хүргэсэн. Мөн БНСУ-д халууны улиралд жижиг дунд үйлдвэрүүдэд их бага хэмжээний үйлдвэрлэлийн осол, аваар гардаг тул үүнтэй холбоотойгоор хөдөлмөрийн аюулгүй байдлаа ханган ажиллах талаар сэрэмжлүүлэг мэдээг бэлтгэн гэрээт иргэдэд мессежээр хүргэсэн.

2024 оны 06 сарын 30-ны өдөр “Гэрээний залуусын нэгдэл” төрийн бус байгууллагатай хамтран “Гадаадад амьдрах сэтгэл зүйн асуудлыг даван туулах нь”, “Хөдөлмөрийн гэрээт иргэдийн ажлын байр солих”-той холбоотой сэдвүүдийн хүрээнд дэлгэрэнгүй ярилцлага хийж, мэдээ, мэдээлэл өгч ажиллав.

Тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор 544, үүнээс 460 иргэн, даатгуулагч, ажил олгогчид утсаар, 84 иргэн, даатгуулагчдад биечлэн Нийгмийн хамгааллын тухай,

Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар болон бусад төрлийн мэдээлэл, заавар, зөвлөгөө өгч, сурталчилгааны материал тараан ажиллав.

3.2 Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд

БНСУ дахь Элчин сайдын яаманд Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн 27 дугаар салбар комисс байгуулагдан ажиллахад Төвийн дөрвөн албан хаагч 6 сарын 20-23-ныг дуустал 4 өдөр туслалцаа үзүүлж ажилласан.

БНСУ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хэрэг эрхлэх газрын сургалтад Төвийн 7 ажилтан хамрагдсан.

2024 оны 06 сарын 30-ны өдөр эрүүл мэндийн үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлдэг эмнэлгүүдтэй хамтран ажилладаг "Сөүл Монгол" сайн дурын үйлчилгээний байгууллагын үүсгэн байгуулагч Им Дэ Хвантай уулзаж, Монгол улсын иргэдийг, тэр дундаа хууль бусаар ажиллаж, амьдарч байгаа хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийг эмнэлгийн үнэ төлбөргүй үзлэгт хамруулах талаар хамтран ажиллахаар болов.

БНСУ-ын Хөдөлмөр халамжийн корпорацийн хүсэлтээр Үйлдвэрлэлийн ослын даатгалын газрын 60 жилийн ойн арга хэмжээтэй танилцах уулзалтад Төвийн ажилтнууд оролцсон.

БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт хөдөлмөрийн яамнаас зохион байгуулдаг БНСУ-д мэргэжлийн бус ажиллах хүчний E-9 визээр ажиллаж байгаа хөдөлмөрийн гэрээт иргэдийг амжилттай нутаг буцахад нь дэмжих зорилгоор К-дижитал трэйнинг сургалт, мэдээлэл технологийн боловсрол олгох үйл ажиллагаа эрхэлдэг "Спретикс" ХХК-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд тус компаниас хамтарсан танилцуулга, тараах материал 2000 ширхгийг хэвлүүлж өглөө.

3.3 Сургалт, судалгааны ажлын хүрээнд

БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хөгжлийн сангийн Ёжү хот дахь Олон улсын сургалтын төвд очин 2024 оны 06 сарын 27-нд шинээр ирсэн 29 гэрээт иргэдэд ирсний дараах сургалтыг танхимаар зохион байгуулсан. Эдгээр иргэдэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасгийн үйлчилгээ, АҮХНХЭГ-аас болон Цагаачлалын албанаас зохион байгуулж буй Солонгос хэлний төрөл бүрийн сургалт, урьдчилсан үнэлгээ хийх шалгалтуудын хуваарь, цалин хөлс тооцох заавар, ажлын байр солих талаарх мэдээлэл, үйлдвэрлэлийн осол болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө зэрэг дараах агуулгын хүрээнд мэдээлэл өгч, тараах материал бэлтгэж өгсөн.

Шинээр хөдөлмөрийн гэрээгээр ирж буй 20 иргэнд 2024 оны 06 сарын 21-ний өдөр ирэхийн өмнөх сургалтыг дараах агуулгын хүрээнд цахимаар хийлээ. Үүнд:

- ХНХҮТ-ийн үйл ажиллагааны товч танилцуулга
- Солонгос Улсын хууль, дүрэм, журам
- Монгол иргэдийн гэмт хэрэгт холбогдож буй байдал
- Үйлдвэрлэлийн осол, үйлдвэрлэлийн ослын даатгал,
- ХАБЭА-н талаарх Солонгос үг хэллэг, ослоос урьдчилан сэргийлэх
- Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйл
- Ур чадвартай ажиллах хүч E7 визний талаар

- Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу талуудын талаар.

3.4 Бусад, дотоод ажлын хүрээнд

Төвийн Ёс зүйн дэд хорооны хурал 3 удаа хуралдаж, ёс зүйн зөрчлийн асуудлаар хандсан 1 иргэний өргөдөл гомдлыг хэлэлцэн, хянаж үзээд дүгнэлт шийдвэр гаргав. Ёс зүйн дэд хорооны 2024 оны эхний хагас жилийн тайланг төвийн удирдлагад танилцуулсан.

Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан болзол нөхцөлийг хангасан, нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авах эрх үүссэн 9 даатгуулагчид зохих журмын дагуу даатгуулагчийн тодорхойлолтыг гаргаж, шаардлагатай бичиг баримтыг Монгол хэл рүү хөрвүүлж өгөв.

Нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн 06 дугаар сарын шимтгэлийн орлогыг НДЕГ-ын Төрийн сан дахь холбогдох дансанд шилжүүлэн, тайлан мэдээг гарган НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газрын холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.

2024 оны 05 дугаар сар, эхний хагас жилийн гүйцэтгэлийн болон үйл ажиллагааны тайлан мэдээг нэгтгэн боловсруулж, НДЕГ, ХНХЯ-нд тус тус хүргүүлэв.

Төвийн “Ёс зүйн дэд хороо”-ноос 06 дугаар сарын 27-ны өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн танилцуулгыг хийж, сургалт зохион байгуулав.